



# «МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО»-НЫ ЗАРИМ ҮГИЙН ТАЙЛБАР

*МУБИС - ийн докторант Д.Туяа*

Утга зохиолын хэл болон бусад нутгийн аялгуунд тааралддаггүй, зөвхөн бичгийн дурсгалуудад тохиолддог ховор сонин үгс, тэр ч байтугай бичгийн дурсгалуудад ч байдаггүй өдий төдий хуучирсан үгс хадгалагдан үлдсэн дархад аман аялгууны үгсийн санг судлах нь хэл шинжлэлийн олон асуудлыг шийдвэрлэхэд чухал алхам болох төдийгүй монгол хэлний олон нутгийн аялгууны үгс утга зохиолын хэлэндээ жигдран уусах хандлага илүү хурдацтай болж байгаа энэ үед дархад аман аялгууны үгсийн санг тусгайлан судалсан бүтээл нэн шаардлагатайн үүднээс бид дархад аман аялгууны үгсийн сангийн онцлогийг судалж өвөрмөц үгийн тайлбарыг хийхээр сэдэв сонгон ажиллаж байгаа билээ. Бид энэ сэдвийн хүрээнд ажиллаж байхдаа “Монголын нууц товчоо”-ны судлаачдын анхаарлыг ихэд татаж, маргаантай байгаа зарим үг хэллэгүүдийг дархад аман аялгууны үг хэллэгтэй оноон тайлбарлаж болох уу гэсэн асуудлыг дэвшүүлэн тавьж үүнд хариулахыг оролдсон юм.

“Монголын нууц товчоо” хэмээх хосгүй гайхам дурсгалыг анх монгол бичгээр бичсэн нь тодорхой боловч бидэнд одоо хэр тэр эх олдоогүйгээс эртний зарим үг хэллэгийг тайлбарлахад бэрхшээл гарч гадаад дотоодын олон олон эрдэмтэн мэргэд оюунаа чилээн хичээл зүтгэл гаргасаар байна. “Далайд дусал нэмэр” гэгчийн үлгэрээр өөрсдийн чадан ядан хийсэн тайлбарыг олон зуун жилийн түүхтэй “Монголын нууц товчоо”-ы судлалд өргөн барьж буйг маань болгоон үзэж “Монголын нууц товчоо”-ны эхийг хэтэрхий гуйвуулж, буруу ташаа мэдээлэл болсон гэж үзвэл өршөөн үзэж, зааж зөвлөхийг хүсэж байгааг маань хүлээн авна уу.

“МНТ”-ны 30 гаруй үгийг сонгон авч дархад аман аялгууны үгтэй харьцуулан тайлбарласан ба үүнээс сонгон дараах таван үгийн тайлбарыг танилцуулъя. Үүнд: “МНТ”-ны 8, 131, 194, 246, 254-р зүйлийн “төхөм, хирү’эсэ, чима, жибгүрэжүхүй, жүл” зэрэг үгийг тайлбарласан өмнөх судлаачдын тайлбар дүгнэлтийг дархад аман аялгууны үгтэй харьцуулан дараах саналыг дэвшүүлж байна.

## 1. “Хөл Баргужин төхөм” гэсэн үгийн “төхөм” гэсний тайлбар

“Монголын Нууц товчоо”-ны 8-р зүйлийн “төхүм” гэсэн үгийн тайлбарыг Ц.Дамдинсүрэн “Монголын Нууц Товчоо”-д “төхүм”, Лувсанданзан “Алтан товч”-д

“түмэд”, Д.Пүрэвдорж “Монгол Улсын Нууц товчооны шинэ орчуулга тайлбар”-т Я.Цэвэл “Монгол хэлний тайлбар толь. 553-р тал) болон бусад ишлэлийн дагуу дөхөм гэсэн үгээр, Д.Цэрэнсодном “төхөм”, Шагжа. МҮДТ.621-р тал “төхөм-хотгор, хонхор гэх зэргээр бичжээ.

Тэгвэл “төхөм” гэсэн үг нь дархад аман аялгуунд хужир ихтэй бага хэмжээний нуур гэсэн утгатай (Чанасан цайныхаа хужирыг ихдүүлэхэд “Хээ ёстой төхөм чанасан байна даа” гэж хэлдэг. ) байдаг тул энэ үгийг “Нууц товчоо”-ны галигийн дагуу төхүм, төхөм гэж бичих нь зүйтэй юм. Бидний нэмэн тайлбарлаж байгаа утга нь дээрх эрдэмтдийн хотгор хонхор газар гэсэн утга дээр нэмээд хужиртай нуур, тойрмыг хэлдэг гэсэн санал юм. Нуурын хөл гэвэл нуурын адаг гэсэн утгатай байдаг тул “МНТ”-ны “Хөл Баргужин төхөм” гэсэн хэллэгийг “Хужиртай нуур Баргужины адаг хавиар нутагладаг” гэсэн санаагаар тайлбарлаж болох мэт.

“Төхөм” гэсэн үгийн утгыг монгол хэлний хэлцийн утгаас хөөж үзвэл “Төрд хуурай ширүүн төхөмд зараа ширүүн” гэж хэлэлцдэг. Тэгвэл энэ хэлц үгийн сүүлийн хэсгийн утга нь гахай өөрийгөө шавраар хуягладаг шиг, зараа нь шавраар өөрийгөө хуягладаг амьтан билээ. Тэгвэл хужиртай нуурын шавраар өөрийгөө хуягласан зарааны өргөс хэр ширүүн байх нь тодорхой. Үүнээс ухвал “төхөм” гэсэн үг маань “хужиртай нуур” гэсэн үгээр тайлбар хийж болох мэт санагдана.

## 2. “kirese-ece” буюу “kilüse-ece” гэсэн үгийн тайлбар

МНТ-ны 131-р зүйлд “biden-ü kirese-ece(хирү’эсэ-эцэ...)” гэсэн хэлбэрийг Хэниш “kilү’эсэ” (E.Haenisch. Wörterbuch zu Manghul-un niuca tobca’an(Vuan-chaopi-shi)Geheime Geschichte der Mongolen. Leipzig, 1939. Page.102 (II, Aufl., Wiesbaden, 1962) Б.Сумъяабаатар 131-ийн 3-р тайлбарт “kilügese- ece(kirügese), Д.Цэрэнсодном “Монголын Нууц товчооны орчуулга тайлбар”-ын 260-р тал. 203 –р тайлбарт “ кирү’эсэ гэдгийг хятад хадмалд (мориноос буух газар) гэж орчуулжээ. Уг үг гарлын хувьд ОЦМХ-ний дунд нь холбох, уях гэсэн утгатай хэрээ( сонгодог бичгийн кэрүгэ) гэдэгтэй гарал нэгтэй бололтой. “Юань улсын судар” зэрэг түүхийн сурвалж бичгүүдэд “кирүгэс” гэдгийг ордны гадна морь уях газар, морь зэллэх газар гэж хэлдэгтэй нийлж байна.”. Ш.Гаадамба “Энэ үгийн



утгыг Хэниш, Пеллио, Рахевильз, Поуха, Калужинский нар цөм хадмал хятад орчуулгыг дагаж “морины талбай, морины буудал” гэх зэргээр ойлгосон байхад Дамдинсүрэн, Мансан нар “морины уяанаас” гэж тус тус ойлгож орчуулсан байна. Бидний бодвол энэ үгийг “кирүгэс”= “хэрэгэс-эчэ” гэж сэргээх нь зөв гэж бодно. Учир нь нэгд кирүгэс гэж бичвэл уяа биш мод таслан хөрөөдөх хөрөөний нэр болно. Хоёрт, Шагж багшийн толинд “хэрэгэ-жүчүгэн-ү кэрэгэ” гэж бичсэн бидний санахад хэлэлцэж буй үгийн эртний уламжлалт бичлэгийн хэлбэр нь мөнөөс зайлахгүй. Морь хэрэх гэгч морьдыг хөлөөр нь аргамжаар холбож уяхын нэр бөгөөд бас хоёр шонгийн хооронд татсан сур дээс зэргээр холбож уясныг монгол бичгээр “хэчэ” гэж нэрлэдгээс үзвэл “хэц, хэрэ+хэрэгэ цөм гарал нэгтэй төрөл үг болов уу гэж санах учир “хэрэгэс –эчэ” гэж сийрүүлэв” (Ш.Гаадамба “МНТ” УБ”, 1990.319-320-р тал. 445-р тайлбар) гэжээ.

Дархад аман аялгуунд морины уяа болох хоёр цэргэ(шон)-ний хооронд татсан суран уяаг “хирэм” гэж нэрлэдэг учир “kirese-ece” гэсэн энэ үгтэй гарал нэг байх боломжтой санагдана. Дархад аман аялгуунд “хирэм” гэж нэрлэж байгаа энэ хэлбэр нь бас “өмдний тэлээ” гэсэн утгатай байна. Эртний монгол хэлэнд аливааг бэхэлж, холбон уяж, торгох хэрэгслийг хирэм, хирээс гэж нэрлэж байсны эртний хэлбэр үлдэж хоцорсон мөн энэ үг нь хэрж уяхаас гадна хиллэн тогтоох гэсэн утга илэрхийлж хил гэсэн үгтэй нэг язгууртай биш биз гэсэн санал байна. Тэгвэл энэ үгийн эртний хэлбэр нь эрдэмтэн Ш.Гаадамба гуайн тайлбарласны дагуу заавал “хэрэгэсү” гэж бичих албагүй, “хирэгэсү” байсан ч болох мэт санагдана.

### 3. “Чима хайран” гэсэн үгийн тайлбар

“Монголын Нууц товчоо”-ны 194-р зүйлд “...Гүрбэсүүг авчирч цэрэг захируулах билүү? Чима хайран, Хүгсүү сабраг баатар өглөөд цэргийн цааз сулрав. Монголын завшаан болох биз. Бид дийлдэх болно.” гэсэн өгүүлбэрийн “Чима” гэдгийг хятад хадмалд шүүрс алдах дуу гэж тэмдэглэснийг олон судлаачид ишилсэн байдаг.

Энэ үгийг Ц.Дамдинсүрэн “Монголын Нууц товчоо”-ны 157-р талд Хөөрхий, Д.Цэрэнсодном “Монголын Нууц товчооны орчуулга тайлбар”-т “Ай халаг” Ш.Гаадамба “чима хайран” гэдэг харамсах аялга үгсийн чима нь “чи бас”(чаабаас) гэдэг өөр харамсах үгийн нэг хувилбар бус, харин чимлах (харамсах) гэдэг үгийн язгуур аялга үг болно”(Ш. Гаадамба “МНТ” УБ., 1990.363-р тал.567-р тайлбар) гэх зэргээр хөрвүүлжээ.

Дархад аман аялгуунд энэ уулга алдсан “Чима” гэдэг эртний үг нь хоёр утгаар идэвхтэй хэрэглэгдэж байна. Жишээлбэл: 1. Чуг чамай, (сам ) (Чог чамай) таатай юм, Болохкээ байвооч гэвэл өмнө нь анхааруулаад байсан байтал үгэнд нь ороогүй учраас ихэд тавласан өнгө аястай энэ жишээнд хэрэглэсэн

байна. 2.Аа чамай аав ирлээ гэвэл аавыг ирсэнд талархсан өнгө аясаар хэрэглэжээ. Тэгвэл “Монголын Нууц товчоо”-ны “Чама” гэсэн бүтэц бус өгүүлбэрийг Хорису-бэчи Таян ханыг ихэд тавлаж, уурласан өнгө аясаар “Чима хайран” гэсэн үгийг хэрэглэсэн байна. Бидний шүүрдэн үзсэн аман аялгууны материал, толь бичгүүдэд дархад аман аялгуунаас өөр аялгуунд энэ хэлбэр одоогоор хараахан тэмдэглэгдээгүй байна.

### 4. “жибтүрэжүкүй” гэсэн үгийн тайлбар

“МНТ”-ны 246-р зүйлд “Тэв тэнгэрийг үгүй болоод Хонхотаны царай жибтүрэжүкүй” гэсэн өгүүлбэрийн “жибтүрэжүкүй” гэсэн үгийг судлаачид хэрхэн тайлбарласан бэ? Ш.Гаадамба жиб[э]т[э]гүрэжүкүй гэж сэргээн [] хаалтанд өөрийн нэмж сэргээснээ хийсэн ба утгыг “зэвтүү болох” гэж тайлбарлаад “Энэ үгтэй язгуур нэгтэй “жибэгүчэкү-бахан айусукику” айх, өнгө царай нь буурах гэсэн утгатай үг байна”, Ш.Чоймаа “Хонхотаны царай шувтарчухуй(царай алджээ)”, Д.Цэрэнсодном “Хонхотан нар царай алджухуй.”, Ц.Дамдинсүрэн “Хонхотны хөвгүүд номхров” гэх мэтээр тайлжээ. Дархад аман аялгуунд байгаа “живөө хүрэх, живөөтэй, живөөрхөх” гэсэн үг байгаа нь энэ үгтэй нэг гаралтай биш биз гэсэн бидний санал байна. Утга зохиолын хэлний “зэвүү” гэсэн үгийг дархадад “живөө”, зэвүүрхэх, зэвүүцэх гэвэл “живөөрхөх” гэх мэтээр хэлнэ. Энэ нь ихэд дургүйцэх, эгдүүцэх, эсвэл дургүйцэн айх гэсэн утгаар бас хэрэглэгдэнэ. Үүнээс үзвэл Ш.Гаадамба эрдэмтэнтэй бидний санал нэг байна. Дээрх зарим эрдэмтдийн тайлбарт байгаа шиг “номхорсон, царай алдсан” гэсэн утга биш харин эгдүүцэн айж дургүйцсэн “Хонхотан нар живгүрхэжүхүй” буюу “Хонхотан нар живөөрхжээ” гэсэн үг байсан биш биз гэж бодно.

### 5. Жүл (жул, гүл, чүл, цул, чулу) гэсэн үгийн тайлбар

“МНТ”-ны 254-р зүйлд “Цагаадай энэ мэргэдийн жүл олжагур-а хэрхэн мэдүүлэх” гэсэн өгүүлбэр бий. Энд байгаа “жүл олжагур-а” гэсэн үгийг оноон тайлбарласан эрдэмтдийн тайлбарыг харъя. Хятад үсгийн галигаас нь Хэниш “чүл’үл жа’ура эсвэл чүл илжа’ура” гэж хоёр янз тайлбарлан утгыг “олзны хүүхэд”, “бутач хүү”, Козин “чулоул жаура”, Пеллио “гүл үл жа’ура”, Мансан “чулу олжабури” буюу “чул олзвор(холимоггүй олзны хүү), Дашцэдэн “чул улжаура”, Элдэнтэй, Ардаажав “чолгул-жагур-а” удум(цусан сүлбээ), Д.Цэрэнсодном “чул олзуурт”, Ш.Гаадамба “жүл олжагур-а” энэ “жүл” гэдэг нь “жулбудасу”, “жулжаг-а” гэх мэт үгийн үндэс болсон үг тул хүнийг доромжлох “жулдрай”, “дорой донгио” гэсэн үг байх гэх мэтээр тайлбарлажээ. Энэ үгийг дархад аман аялгууны үүднээс дүүлгэн тайлбарлахыг оролдье. Дархадад “жүлбэ” гэсэн үг нь аливаа юмны үлдвэр гэсэн утгатай байна. Тухайлбал, Жүлбэний мал-өөрийнх нь эцэг өвгөдийн үеэс удам дамжин ирсэн



малын үр төл эсвэл тухайн малын удмын сан гэсэн утгатай байна. Дархадудын жүлбэ гэсэн үгийг “Хөл малын хөрөнгө хөгшин гүүний минь унага” гэсэн үг гэж тайлбарлаж байна. Мөн “Тэвшний минь ёроол, хөрөнгөний минь жүлбийг битгий тасал” гэвэл- Тухайн хүний амь зуулгын хөрөнгийн үлдвэрийг битгий тасал гэсэн утга байна. Энэ нь Я.Цэвэл “Монгол хэлний тайлбар толь”-д зүлчгэр ураг төрөлдөө элэгсэггүй” гэсэн үгтэй гарал нэгтэй байх боломжтой мэт. Учир нь “зүлчгэр” ураг төрөлдөө элэгсэггүй гэсэн үгийн язгуур “зүл”-д тухайн хүний удам судар үлдвэр гэсэн утга байна гэж ойлгож байна. Энэ үгийн язгуурыг монгол

бичгээр “fɪl” гэж бичжээ. Монгол бичгийн хэлний ардаа “i”-ээс бусадэгшигтэй байсан “fi” нь орчин цагийн монгол хэлэнд “з” болсон байдаг. Гэтэл дархад аман аялгуунд “з” бололгүй “ж” хэвээр үлджээ.”бэ” нь нэр үг үүсгэх дагавар юм. Тэгвэл “Нууц товчоо”-нд болон судлаачдын тайлбарт байгаа “чүл, гүл, цүл, цул, жул” гэсэн үгтэй дархад аман аялгууны “жүлбэ” гэсэн үгийн “жүл” нэг язгууртай байх боломжтой. Тэгвэл үүнийг хятад галигийн дагуу “жүл” гэж бичвэл тухайн үгийн утга сая нутгийн аман аялгууны үүднээс тайлбарлахад боломжтой болж энэ нь Зүчийг мэргэдийн жүлбэ юм гэсэн утга тодрох мэт санагдана.

### ДҮГНЭЛТ

1. Төхөм гэсэн үг нь хужиртай нуур гэсэн үг
2. “kirese-ece” гэсэн үг нь хирэм гэсэн үгтэй нэг язгуур, нэг утгатай үг
3. “Чима” гэсэн үг нь эртний энэ хэлбэрээрээ дархад аман аялгуунд одоо ч хэрэглэгдсээр байна
4. “жибтүрэжүкүй” гэсэн үг нь номхдох, царай алдах гэсэн үг бус ихэд дургүйцэн эгдүүцэх, эсвэл дургүйцэн айх гэсэн утгатай “живөөрхжээ” гэсэн үг
5. “жүл олжагур-а” гэсэн үгийн “жүл” гэсэн нь юмны үлдвэр гэсэн утгатай учир “жүл” гэж бичих нь зөв

#### Санал

Дархад аман аялгуу нь монгол хэлний эрт эдүгээгийн бичгийн дурсгалуудтай нийлж хэлний хөгжлийн явц, түүхийг тусган харуулахаас гадна хэл шинжлэлийн шийдвэрлэгээгүй асуудлыг тодруулахад зохих үүрэг гүйцэтгэх юм.

Цаашилбал, орчин цагийн монгол хэлний үгсийн санг баяжуулах, хэлний зүйн тогтол, хөгжлийн үе шатыг тодорхойлоход чухал нөлөөтэй гэж үзэж дархад аман аялгууны үгсийн сангийн талаар нарийн судалгаа хийх нь бас нэг хойшлуулашгүй зорилтын нэг болж байна.

### НОМЗҮЙ

1. Базаррагчаа.М. “Монгол хэлний өгүүлбэр” УБ.,1987
2. Вандуй.Э.”Дөрвөд аман аялгуу” УБ.,1965
3. Вандуй.Э.”Завханы сартуул ба түүний аман аялгуу” Хэл зохиол. 17-р дэвтэр.УБ.,1964
4. Калужинский(Варшав)”Монгол якут хэлний харьцаа”. “Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтдийн анхдугаар их хурал” I дэвтэр. УБ.,1961.119-р тал
5. Лувсанвандан.Ш.нарын “Монгол хэлнүүдийн харьцуулсан хэл зүй” УБ.,1985
6. Мөөмөө.С. Ю.Мөнх-Амгалан “Орчин үеийн монгол хэл аялгуу” УБ.,1982
7. Санжеев. Г.Д. “Дархатский говор и фольклор” Лг.,1931г
8. Төмөртоого. Д. “Монгол хэл шинжлэлийн онол түүхийн асуудлууд” УБ., 2002
9. Туяа. Д., Туул. Д. “Дархад аман аялгууны товч толь” УБ., 2008
10. Туяа.Д.”МНТ”-ны зарим үгийг дархад аман аялгууны мөн үгтэй холбон тайлбарлах нь” Нийгмийн ухааны салбарын “Хүрэлтоогоот-2008” эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлүүдийн эмхтгэл УБ., 2008 он
11. E.Haenisch. Wörterbuch zu Manghul-un niuca tobca'an(Vuan-chaopi-shi)Geheime Geschichte der Mongolen. Leipzig, 1939. Page.102 (II, Aufl., Wiesbaden, 1962)
12. Цолоо. Ж. “Хотгойд аман аялгууны зарим онцлогоос” ШУА-ийн мэдээ УБ., 1962.№4
13. Цолоо. Ж. “Урианхай аялгууг судалсан зарим дүн” Хэл зохиол.УБ., 1972.9
14. Цолоо. Ж. “Захчин аман аялгуу” Хэл зохиол. УБ.,1965. III боть



15. Гаадамба.Ш. “Монголын Нууц товчоо”-ны судлалын зарим асуудал Уб., 1990
16. Дамдинсүрэн.Ц. “Монголын Нууц товчоо” Уб., 1990
17. Козин.С.А. Сокровенное сказание Монголов. Л.,1941.стр.301
18. Лувсанданзан “Алтан товч”
19. Мансанг. Шинэ-бэр орчигулжу тайилбурлагсан “Монггол-ун нигуча тобчийан” Көкэхота.,1985. тал.337
20. Пүрэвдорж.Д. “Монгол Улсын Нууц товчооны шинэ орчуулга тайлбар”
21. Pelliot.P. “Histoire secrete des Mongols” Paris.,1949.page.103
22. Сумъяабаатар.Б. “Монголын Нууц товчооны үсгийн галиг” Уб.,1990
23. Хандсүрэн.Ц. “Цэнд гүн ба Монголын Нууц товчоо” Уб., 2002
24. Цэвэл.Я “Монгол бичгийн товч тайлбар толь” Уб.,1966
25. Цэрэнсодном.Д. “Монголын Нууц товчооны орчуулга тайлбар” Уб., 2000
26. Чоймаа.Ш “МНТ”, Лувсанданзаны “Алтан товч” эхийн харьцуулсан судалгаа Уб., 2002.
27. Шагжа. Монггол үсүг-үн дүрэм-үн толи бичик. Уб.,1937. тал.354
28. Элдэнтэй, Ардаажав “Монггол-ун нигуча тобчийан-сэйирэгүлүл тайилбури” Көкэхота.,1986. тал. 836-837